

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ИМПОРТЫН ХАРААТ БАЙДЛЫГ БУУРУУЛАХАД БНХАУ-ЫН НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛ

С. Энхцэцэг¹

Ард түмний амьдралыг тэтгэх цөөн төрлийн чухал хүчин зүйлсийн нэг нь үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндэс, стратегийн чухал бүтээгдэхүүн болох газрын тос, эрчим хүчний хангамжийн асуудал бөгөөд өнөө үед улам бүр чухлаар тавигдаж байна. Хятад улсын эрчим хүчний хангамж өнөөгийн эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн хурдыг гүйцэхгүй байгаа тул үндэсний аюулгүй байдал, стратегийн хөгжлийг хангахад томоохон сорилттой тулгарч байна. Дэлхийн хоёрдогч том газрын тос импортлогч орны хувьд Хятадын эрчим хүчний дипломат бодлого дэлхийн эрчим хүчний бодлогод гүнзгий нөлөө үзүүлэх боломжтой юм.²

I. БНХАУ-ын эрчим хүчний салбарын онцлог:

Дэлхийн банкны судалгаагаар Хятадын газрын тос дэлхийн нөөцийн 2.4%, байгалийн хийн нөөц 1.2%-ийг тус тус эзэлдэг байна. Газрын тосны хэрэглээ жилд 7% өснө гэж шинжээчид урьдчилан тооцоолж байсан ч 1996 оноос тосны олборлолтын өсөлт 1.2% хүрч тогтмолжсон нь олборлолт хэрэглээний өсөлтөөс хэд дахин хоцорч, улмаар 2030 онд өнөөгийн түвшнээс бүр буурах болжээ. Энэ нь Зүүн хойд Хятадын газрын тосны үндсэн орд газрууд болох Дацин, Шэнли, Ляхоэгийн нөөц хязгаарлагдмал, нөгөө талаас нутгийн баруун хэсэгт орших газрын тос, байгалийн хийн орд газруудыг эзэмшээгүйтэй холбоотой ажээ. Хятадын эрчим хүчний 2020 он хүртэлх стратегид: эрчим хүчний хэрэглээний бүтцийг өөрчилж, нүүрсний хэрэглээг дунджаар 62%, байгалийн хийг 6.8%, газрын тосыг 25.8% болгох зорилт дэвшүүлсэн ба газрын тосны дотоодын олборлолт 180-200 сая тонн, хэрэглээ 450-610 сая тонн хүрэх буюу 2000 онтой харьцуулахад 2-0.6 дахин өснө гэж тооцоолжээ. Дээрх тооцоо судалгаанаас үзвэл Хятад газрын тос, байгалийн хийн эзлэх жинг өсгөж, нүүрсний хэмжээг багасгах зорилго тавьж буй боловч эрчим хүчний хэрэглээний бүтцэд зарчмын томоохон өөрчлөлт гарахааргүй байна. Харин дотоодын газрын тос олборлолтыг ихэсгэх магадлал бага байгаа тул гадаадаас импортлох газрын тосны бүтээгдэхүүний хэмжээ өсөх төлөвтэй байна.


Хятадын өнөөгийн нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 70 орчим хувийг аж үйлдвэрийн салбар, үлдэх хэсгийг нь орон сууц, худалдаа, тээврийн салбар эзэлж байгаа юм. Аж үйлдвэрийн салбарын бүтээмж өссөнөөр эрчим хүчний эрэлт огцом өсч хангамжийн тогтолцоог сулруулав. Эрчим хүчний хэрэглээний 67 хувийг хангадаг нүүрсний эрэлт 2001 оноос хойш жил бүр 12 хувиар, газрын тосны эрэлт 9 хувиас 15% хүртэл өссөн байна. /зураг 1/

¹ МУИС, ОУХС-ийн багш

² Энэхүү өгүүлэлийг Монгол улс, БНХАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойд зориулав.

Зураг 1

Figure 16: China's Energy Supply by Fuel (2005)




Source: CEIC from China Statistical

Дээрх зургаас үзэхэд газрын тос Хятадын эрчим хүчний хэрэглээний 21 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь 1990 онд 17 хувь байжээ. Өдөрт 5 сая баррелиар өссөн буюу 1990 онд 2.3 хувийн өсөлттэй байсан бол 2006 онд 7.2 хүрчээ. Хятад улсын дотоодын газрын тосны үйлдвэрлэлийн хэмжээ өдөрт 3.7 сая баррель ажээ.³ Байгалийн хий нийт хэрэглээний 3 орчим хувийг эзэлж буй боловч сүүлийн жилүүдэд химийн үйлдвэрлэлийн үсрэнгүй хөгжил, гэр ахуйн зориулалтаар ашиглах нь эрс нэмэгдэж буй тул цаашид улам өсөх хандлагатай. Байгалийн хийн үйлдвэрлэл өсөн нэмэгдэж байгаа ч мөн эрэлтийг гүйцэхгүй байна. Судлаачдын үзэж байгаагаар Хятад улс 2020 оны орчим байгалийн хийн хэрэглээ 200 bcm болох буюу өнөөгийн хэрэглээ 4 дахин өснө хэмээн тооцоолжээ.

Хятадын эрчим хүчний хангамжийн хамгийн эмзэг асуудал нь гадаадаас импортын хараат байдалд хүргэж болох газрын тос олборлолт болон хэрэглээ хоорондын зөрөө улам өсч байгаа явдал юм.

Зураг 2

Figure 20: China's Domestic Oil Production and Total Demand



Source: CEIC and IEA and author's estimates.

Хятадын эдийн засаг өсөхийн хирээр түүний эрчим хүчний хэрэглээ хурдтай өсч, цаашид ч улам нэмэгдэх хандлагатай байна. Хятадын ДНБ 1980-2000 онд дунджаар 9.7% өссөн бол эрчим хүчний хэрэглээ 4.6%-иар нэмэгдсэн тул Хятад улс 1993 оноос газрын тос импортолж эхэлжээ. Хятадын албан ёсны мэдээгээр 2002 онд улс орны газрын тосны нийт хэрэглээний 31%-ийг импортолсон бол 2007 оны сүүлээр 50%, зарим урьдчилсан судалгаагаар 2020 онд 77% болж нэмэгдэх ажээ.

2010 онд Хятадын газрын тосны хэрэглээ 350-380 сая тонноор, 24.5 тэрбум кубметр, байгалийн хий 100-120 тэрбум кубметр болж өсөхөөр тооцжээ⁴. 2010 онд газрын тосны дотоодын нийлүүлэлт дунджаар 170-190 сая тонн, байгалийн хийн үйлдвэрлэлийн хэмжээ 80-100 тэрбум кубметрээр тус бүр өсөх боловч хэрэглээний өсөлтийг гүйцэхгүй тул импортыг нэмэгдүүлэхээс өөр аргагүй байгаа нь эрчим хүчний дипломат бодлого Хятад улсын хувьд улам бүр чухлаар тавигдаж байна.

³ Daniel H. Rosen, Trevor Houser "China Energy: A Guide for the Perplexed" May, 2007. p.17

⁴ Dr. Xu Qinhua: "China's Energy Diplomacy and its Implications for Global Energy Security", FES Briefing Paper 13, August 2007 p.2

Хятадын эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадал жил ирэх тутам сайжирч зарим нэг үзүүлэлтээрээ дэлхийд тэргүүлэх хэмжээнд хүрчээ. Үүнд нүүрсний эрчим хүч үйлдвэрлэлийн хэмжээ 2.19 тэрбум тоннд хүрч дэлхийд 1 байр, 181 сая тонн газрын тосны үйлдвэрлэлээр 6-р байр, байгалийн хийн боловсруулах хэмжээгээрээ дэлхийд 2 байрыг тус тус эзлэх болжээ. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд эрчимтэй өсч Хятадын эрчим хүчний хэрэглээний бүтцэд гүнзгий өөрчлөлт гарсаар байна. 2005 онд Хятад улс нийт 2.225 тэрбум тонн нүүрсний хэрэглээгээрээ дэлхийд хоёрдогч эрчим хүчний томоохон хэрэглэгч болсон юм. Хэрэглээний бүтцээ боловсронгуй болгоход ихээхэн анхаарсны үр дүнд дээд зэргийн чанартай цэвэр эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ өсчээ. 1990-2005 оны хооронд нүүрсний хэрэглээ 76.2- 68.7 хувь хүртэл буурч харин газрын тос, байгалийн хийн хэрэглээ 18.7 – 24 хувиар, усан цахилгаан станц, атомын эрчим хүчний үйлдвэрлэл 5.1-7.3 хувиар тус тус өсчээ.

Зураг 3




Figure 2: China's power generation mix

1993 оноос эхлэн газрын тос импортолж эхэлсэн бөгөөд 2005 онд нийт 136 сая тонн хэмжээнд хүрсэн нь нийт хэрэглээний 44% -тай тэнцэж байгаа юм. Энэ нь цаашид улам бүр өсөн нэмэгдэх хандлагатай байгаа тул дотоодын газрын тос, байгалийн хийн нийлүүлэлт, эрэлт хоорондын хэмжээ улам бүр өсөн нэмэгдэж байгааг зохицуулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд түлхүү анхаарч байна. Үүнд:

- Газрын тос, байгалийн хийн үр ашигтай хэрэглээг бий болгож, эрэлтийг улам бүр өсгөхгүй хяналтандаа байлгах;
- Дотоодын нөөцийг илрүүлэх, хүчин чадлаа оновчтой ашиглахын тулд судалгаа, хайгуулын ажлыг эрчимжүүлэх;
- Технологийн хөгжлийг дэмжих замаар эрчим хүчний бусад шинэ эх үүсвэр, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх, үйлдвэрлэхэд бодлогоо чиглүүлэх;
- Олон улсын газрын тос, байгалийн хийн нөөцийн үр ашигтай хэрэглэх тогтолцоог бүрдүүлэхэд нөлөөтэй оролцох;

Олон улсын газрын тос, байгалийн хийн нөөцийг оновчтой ашиглахын тулд Хятад олон улсын эрчим хүчний хамтын ажиллагааны механизм бүрдүүлэх, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд нөлөөлж чадах, 2020 он хүртэл стратегийн хөгжлийг тодорхойлоход томоохон үүрэг гүйцэтгэж чадахуйц нөлөө бүхий оролцогчийн хувьд идэвхтэй оролцох боломжтой юм.


Эрчим хүчний зарцуулалт ихтэй үйлдвэрийн салбаруудад хөрөнгө оруулалтын урсгал төвлөрч байгаа ч үр ашиг нь нэмэгдэхгүй, шийдвэрлэх асуудлууд улам бүр нэмэгдсээр байгаа тул эрчим хүчний бодлогоор дангаар шийдэх боломжгүй санхүүгийн систем болон бусад төрлийн шинэчлэлийг хэрэгжүүлэх замаар илүү өргөн хүрээтэйгээр цогцоор авч үзэх шаардлагатай байгаа ажээ. Хэдийгээр засгийн газраас эрэлтийг хангахын тулд нөхцөл байдлыг зохицуулах оролдлого хийсээр ирсэн боловч дотоодын зах зээлийн хомсдол, өсөн нэмэгдэж буй импортын араат байдал, үнийн тогтворгүй байдал, байгаль орчны бохирдол зэрэг шийдвэрлэхэд төвөгтэй

олон асуудал зэрэгцэж Хятадын эрчим хүчний бодлогыг гадаад, дотоодод улам бүр эрчимтэй явуулахад хүргэж байна.

Ойрхи Дорнодыг эс тооцвол АНУ, ОХУ, Мексикийн дараа дэлхийд 4-т орох түлш, эрчим хүч үйлдвэрлэгч болохын хувьд /Зураг 5/ Хятад улс нь газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэл өндөр хөгжсөн улс юм.

Зураг 4

Figure 19: Annual Oil Production and Proven Reserves for Top Six Producers (2005)



1993 он хүртэл газрын тосны томоохон экспортлогч байхдаа Зүүн Азийн зах зээлийг түүхий газрын тосоор хангаж байсан түүхтэй. 1970-аад оны сүүлээр Бээжингийн удирдлага аж үйлдвэржих, хөгжилд хүрэхийн тулд газрын тосны үйлдвэрлэлээ 2 дахин нэмэгдүүлж санхүүжилтийн эх үүсвэр олох шаардлагатай хэмээн үзэж байв. Харин газрын тосны томоохон орд, нөөц илрээгүй тул эдийн засгийн шинэчлэлийн бодлогоо хэрэгжүүлэхэд түлхүү анхаарчээ.

Хятадын эрчим хүчний томоохон компаниудын зах зээлд эзлэх байр суурийг авч үзвэл төрийн өмчийн 3 компани голлох үүрэгтэй оролцдог байна. Үйлдвэрлэлийн хэмжээгээр хамгийн том нь 1988 онд Түлш, эрчим хүчний яамны хөрөнгөөр яамны хэмжээний статустайгаар байгуулагдсан China National Petroleum Corporation (CNPC) юм. CNPC нь Exxon, BP, Chevron, Shell –ийн дараа орох дэлхийн 7 дахь том газрын тосны компани юм. (хүснэгт 1)

Хүснэгт 1. Дэлхийн газрын тосны тэргүүлэх 10 компани⁵

2006 он	Компанийн нэр	Эзэмшил	2000 он	Компанийн нэр	Эзэмшил
1	Saudi Aramco / Саудын Араб/	Төрийн	1	Saudi Aramco	Төрийн
2	ExxonMobil / АНУ/	Хувийн	2	PDV	Төрийн
3	NIOC /Иран/	Төрийн	3	ExxonMobil	Хувийн
4	PDV / Венесуэл/	Төрийн	4	NIOC	Төрийн
5	BP /АНУ/	Хувийн	5	Shell	Хувийн
6	Shell /АНУ/	Хувийн	6	BP	Хувийн
7	PetroChina (CNPC)	90% төрийн	7	Pemex	Төрийн
8	Chevron /АНУ/	Хувийн	8	Pertamina	Төрийн
9	Total /АНУ/	Хувийн	9	Total	Хувийн
10	Pemex / Мексик/	Төрийн	10	KPC	Төрийн

China Petroleum and Chemical Corporation (Sinopec) нь Түлш эрчим хүчний яам, Химийн үйлдвэрийн Яамны хамтын оролцоотойгоор 1983 онд байгуулагдсан бөгөөд дэлхийд газрын

⁵ Energy Intelligence Research, “The Energy Intelligence Top 100: Ranking the World’s Oil Companies,” 2007 and 2001 editions.

тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр 30-р байранд ордог боловч орлогын хэмжээгээрээ CNPC-ээсээ давдаг байна.

Гурав дахь томоохон компани CNOOC нь 1982 онд далайн эргийн газрын тосны нөөцийг олон улсын томоохон газрын тосны компаниудтай хамтран ашиглах зорилгоор байгуулагдсан. Энэ нь бусадтайгаа адил яамны статусгүй ч (Shell- тэй хамтран) боловсруулах үйлдвэр, түлш эрчим хүчний үйлдвэрлэлд голлох үүрэгтэй оролцдог томоохон компани юм.

Харин төрийн өмчийн 4 дэх томоохон газрын тосны компани болох Sinochem нь дотооддоо хязгаарлагдмал оролцоотой (гадаад зах зээлд голлох үүрэгтэй) ч худалдаа, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрлэлийн салбарт нөлөө бүхий хөрөнгө оруулагч юм. Бусад олон бие даасан жижиг дунд үйлдвэрүүд нь тээвэр логистикийн үйлчилгээ, хадгалах, боловсруулахад голчлон оролцдог байна.

CNPC нь өмнөд, Sinopec хойд, Sinochem, CNOOC хоёр далайн эргийн дагуу тус тус төвлөрөн үйл ажиллагаа явуулдаг тул дотоодын зах зээлд давамгайлан байр сууриа бэхжүүлэхийн тулд компаниудын хоорондын өрсөлдөөн нилээд хурцдах болжээ. Төрийн өмчийн хүчирхэг 4 компанийн охин компаниуд Шанхай, Гонконг зэрэг томоохон хотуудад ихээхэн төвлөрсөн байдаг. Сүүлийн 10-аад жил эдгээр 4 компанийн зах зээлийн сегментийн төлөөх тэмцэл хурцдаж эхэлсэн бөгөөд газрын тос, байгалийн хийн босоо интеграцчигдсан тогтолцоо бүрдүүлэх үүднээс компаниудын өрсөлдөөнийг нэмэгдүүлэхийн тулд Бээжингийн удирдлага 1998 онд CNPC-д боловсруулах үйлдвэрийн түгээх салбар сүлжээг үлдээж харин Sinopec-д зохих хэмжээний портфелийн хөрөнгийг олгох замаар солилцоо хийх арга хэмжээ авчээ. ⁶

Хүснэгт 2. Хятадын газрын тосны 3 том компанийн хүчин чадавхи (2006)⁷

№	Үзүүлэлтүүд	CNPC	Sinopec	CNOOC
Үйл ажиллагааны үзүүлэлт	Түүхий тосны үйлдвэрлэл (tbpd)	2,140	800	633
	Байгалийн хийн үйлдвэрлэл (bcm)	44.2	7	8.8
	Боловсруулах хүчин чадал (tbpd)	207	2.938	NA
Санхүүгийн үзүүлэлт	Орлогын хэмжээ	101.1	133.5	15.1
	Нийт ашиг	23.2	8.48	5.9
	EBT Margins (percent)	22.9	6.4	38.9
	Ажиллах хүчний тоо (мян)	1.589	730	37

Source: Company press releases, Xinhua News Agency Refers to group level company, not the listed subsidiary. Crude oil converted at 7.33 barrels per ton.

БНХАУ-ын шинэ эрчим хүчний дипломат бодлогын онцлог:

Газрын тос нь онцгой стратегийн бүтээгдэхүүн тул дэлхийн газрын тосны гол нөөц нь нөлөө бүхий улс орнуудын сонирхлын төвд оршдог билээ. Тиймээс дэлхийн улс орнууд оршин тогтнож, хөгжихийн тулд газрын тосны төлөө хурц ширүүн тэмцэж ирсэн түүхтэй. Хятад улс ч газрын тосны нөөцийн төлөө өрсөлдөөнд нөлөө бүхий оролцогчдын зүгээс томоохон эсэргүүцэл, дарамт шахалт тулгарах нь дамжиггүй бөгөөд цаашид ч улам хэцүү төвөгтэй

⁶ Daniel H. Rosen, Trevor Houser "China Energy: A Guide for the Perplexed" May, 2007. p.21

⁷ Мөн тэнд

болох нь тодорхой.

Эдийн засгийн өндөр өсөлтийг хангахын тулд эрчим хүчний өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээнээс улбаалан Хятадын эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх бодлогын ач холбогдол өсч эрчим хүчний импортын эх үүсвэрийг олон сувгаар өргөжүүлэх нь стратеги бодлогын гол зорилго болсон тул өнөөгийн засаг захиргаа дотоодын газрын тосны нөөц, импортын зах зээлийг нэмэгдүүлэх замаар үндэсний аюулгүй байдлаа хангах тогтолцоо бүрдүүлэхийг зорьж байна. Ингэхдээ дан ганц газрын тос үйлдвэрлэгч бүс нутаг, дан ганц дамжуулах хоолойноос хамааралгүй байхад ихээхэн анхаарч байгаа юм.

Эрчим хүчний дипломат бодлого нь Хятадын дипломат бодлогын гол үндэс болсон нь сүүлийн жилүүдэд хийгдсэн дээд хэмжээний айлчлалын үеэр илүү түлхүү хэлэлцэгдэж байгаагаас харагдана. 2006 онд Санкт-Петербург хотноо болсон “Их-8” дээд хэмжээний уулзалтаар нээлттэй, ил тод, үр ашигтай, тэнцвэртэй, шударга өрсөлдөөн бүхий, тогтвортой, оролцогчдын хоорондын яриа хэлэлцээг эрх зүйн хүрээнд сайтар зохицуулсан, байгаль орчинд халгүй эрчим хүчний эх үүсвэрийг бүрдүүлэх зэргээр эрчим хүчний олон улсын тогтолцоог шинэчлэн тогтоох зорилго тавьж зарчмыг тодорхойлсон явдал нь Хятадын шинээр тодорхойлж буй эрчим хүчний бодлоготой ихээхэн уялдах болжээ.

БНХАУ-ын дарга Ху Жин Тао дээрх арга хэмжээнд оролцож хэлсэн үгэндээ: “Хятадын эрчим хүчний стратегийн гол үндэс нь дээд зэргээр эрчим хүчний хэрэглээний үр ашгийг нэмэгдүүлж, дотоодын нөөц боломжиндоо тулгуурлах, байгаль орчныг хамгаалах, олон улсын болон хоёр талын үр ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх, тогтвортой, хэмнэлттэй, цэвэр эрчим хүчний эх үүсвэрээр хангагдсан системийг бүрдүүлэхэд оршино. Тиймээс бид хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж эрчим хүчийг үйлдвэрлэгч, хэрэглэгч бүх улс орнууд эрх тэгш, харилцан үр ашигтай, win-win зарчимд тулгуурлан дэлхийн эрчим хүчний хамтын ажиллагааг бүрдүүлэхэд чиглүүлэх юм” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.⁸

2006 оны 3 сард болсон “БНХАУ-ын нийгэм, эдийн засгийн хөгжлийн 5 жилийн төлөвлөгөө”-ндөө эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан олон улсын газрын тос, байгалийн хийн хөгжлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын эрчим хүчний системд идэвхтэй оролцох, олон улсын зах зээлийн боломжийг бүрэн дүүрэн оновчтой ашиглах замаар Хятадын эрчим хүчний аюулгүй байдлыг хангах болно хэмээн заажээ.

2006 оны 12 сард төвлөрсөн төлөвлөөт эдийн засгийн бага хурлаараа “Good and Fast” хэмээх зарчмыг эдийн засгийн хөгжилдөө хэрэгжүүлэх зорилт дэвшүүлжээ. Ингэхдээ хурд – чанар – үр ашиг гурвын зохицол, хэрэглээ – хөрөнгө оруулалт-экспорт гурвын хослол, хүн ам – нөөц баялаг – байгаль орчны нэгдэл зэрэг нь нийтдээ сайн, хурдтай эдийн засгийн хөгжлийн үндсийг хангах болно хэмээн тодорхойлсон байна.⁹ “Good and Fast” эдийн засгийн хөгжлийн стратеги зорилтын үндэс нь эрчим хүчний аюулгүй байдал, байгаль орчны тогтвортой хөгжлийг хослуулан хөгжүүлэх явдал бөгөөд эрчим хүчний дипломат бодлоготойгоо шууд холбогджээ.

Өнөөгийн Хятад улс нь гадаад импортын эх үүсвэрээр эрчим хүчний нийлүүлэлтээ хангахын тулд тээвэрлэлтийн аюулгүй байдлыг бүрдүүлэх, эрчим хүчний технологийн дэвшлийг хурдасгах, эрчим хүчний хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах зэрэг томоохон сорилтуудтай тулгарсаар байна.

Эрчим хүчний дипломат бодлогын үйл ажиллагаа нь “гадагшаа чиглэсэн” стратеги бодлогоо хэрхэн хэрэгжүүлэхээс ихээхэн шалтгаална. Хятадын голлох эрчим хүчний компаниудын олон улсын хэмжээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа эрчимжиж байна. Төрийн өмчийн томоохон компаниуддаа олон улсын орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх, олон улсын зах зээлийг хөгжүүлэхийн тулд бусад үйлдвэрлэгчдийг дэмжих, бараа бүтээгдэхүүний худалдааг нэмэгдүүлэх, инжинирингийн үйлчилгээ үзүүлэгч томоохон төслийг хэрэгжүүлэх, үндэсний үйлдвэрлэгчдийн технологийн чадавхийг дээшлүүлэхэд шинэ технологи нэвтрүүлэх,

⁸ Dr. Xu Qinhua: “China’s Energy Diplomacy and its Implications for Global Energy Security”, FES Briefing Paper 13, August 2007 p.4

⁹ Мөн тэнд

хамтарсан судалгаа шинжилгээний ажилд оролцохыг дэмжих замаар эрчим хүчний дипломат бодлогоо шаргуу явуулж олон улсын эрчим хүчний салбарт нөлөөгөө бэхжүүлэхэд анхаарч байна.

Хятад улс талуудын харилцан ашигтай хамтын ажиллагаа, хөгжлийн онцлогт нийцсэн, баталгаатай эрчим хүчний шинэ аюулгүй байдлын үзэл баримтлалыг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байгаагаа тогтмол илэрхийлсээр байгаа юм. Эрчим хүчний олон улсын зах зээлийн боломжийг оновчтой ашиглаж, учирч болох эрсдлээс зайлсхийж Хятадын эрчим хүчний нийлүүлэлтийг хангаж чадахуйц олон талт, тогтвортой, уян хатан орчинг бүрдүүлэх, нээлттэй зах зээлийн тогтолцоонд тулгуурласан эрчим хүчний аюулгүй байдлыг хангасан байхад ихээхэн анхаарч байна. Энэ нь өнөөгийн Хятад улсын стратегийн гол сонголт бөгөөд цаашид удаан хугацаанд тогтвортой баримтлах үзэл санаа юм. Үүний тулд Хятад улс хоёр болон олон талт дипломат ажиллагааг оновчтой хэрэгжүүлэх замаар эрчим хүчний хамтын ажиллагаагаа бэхжүүлж нөлөө бүхий үндэсний эрчим хүчний дипломат бодлоготой болохыг зорьж байна.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд эрчим хүчний хөгжил болон экологийн аюулгүй байдал, мөн эрчим хүчний хангамж болон технологийн дэвшил, хөгжлийг зэрэгцүүлэн хөгжүүлэхэд эрчим хүчний дипломат бодлогоо чиглүүлж байна. Эрчим хүчний хангамж, технологийн дэвшил нь эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилтэй шууд холбогдох тул эрчим хүчний хангамжийн урт удаан хугацааны тогтвортой байдлыг бүрдүүлэх нь эрчим хүчний хөгжлийн гол үндсэн зорилго юм.

Технологийн дэвшлийг нэвтрүүлэх замаар эрчим хүчний үр ашигтай байдлыг нэмэгдүүлээд зогсохгүй улмаар эрчим хүчний нөөцийн хомсдлыг ч нөхөх боломжтой тул эрчим хүчний дипломат бодлого нь тогтвортой эрчим хүчний хангамжийг бүрдүүлэхээс гадна технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хурдасгахад голлох үүрэг гүйцэтгэх юм. Эрчим хүчний бодлогоор дамжуулан технологийн дэвшлийг сэргээгдэх эрчим хүчний технологитой адил эрчим хүч хадгалах технологийг нэвтрүүлэх, эрчим хүчний хэрэглээг төрөлжүүлэх, аж үйлдвэрийн болон хэрэглээний өнөөгийн тогтолцоог оновчтой болгох, эрчим хүчний үр ашиггүй хэрэглээ, бохирдлыг бууруулах зэрэгт нэвтрүүлж хэрэгжүүлэх нь оновчтой хэмээн үзэж байна. Олон улсын эрчим хүчний технологийн салбарын хүчтэй өрсөлдөөнд оролцож шинэ эрчим хүчний эх үүсвэрийн стандартыг тогтооход голлох үүрэгтэй оролцоход ихээхэн анхаарч ажиллаж байна. Ялангуяа энэ нь тогтвортой эрчим хүчний эх үүсвэрийг бүрдүүлэх боломж олгох тул эрчим хүчний дипломат бодлогоор дамжуулан олон улсын эрчим хүчний технологийн хамтын ажиллагаанд гүнзгий нэвтрэхэд анхаарч байна.

Эрчим хүчний гол эх үүсвэр болсон газрын тос, байгалийн хийн нөөц багасч, өөр бусад эх үүсвэрээр орлуулах арга замыг дэлхий нийтээрээ хайж байгаа өнөө үед Хятад улс ч сэргээгдэх эрчим хүч болон бусад эх үүсвэрээр эрчим хүч үйлдвэрлэхэд ихээхэн анхаарч судалгаа, шинжилгээний ажлыг ч эрчимтэй хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрч байна. Үүнийг Хятад улс Европын холбоотой хамтран эрчим хүчний хамтын ажиллагаагаа бэхжүүлж томоохон төслүүдэд хамтарч ажиллаж байгаагаас харж болох юм.

Эрчим хүчний хөгжил болон экологийн аюулгүй байдал хоёрыг зэрэгцүүлэн оновчтой хөгжүүлэхэд томоохон сорилт тулгарч байгаа тул оновчтой шийдвэрлэхийн тулд тэнцвэрийг хангах ёстой хэмээн үзэж байна. Өнөөгийн байдлаар Хятад улсад экологийн асуудал туйлын чухлаар тавигдаж байгаа юм. Хүн амын дийлэнх хэсэг нь зүүн хэсгээрээ оршин сууж хэт төвлөрсөн тул эрчим хүчний хэрэглээний нягтрал нэмэгдэж улмаар байгаль орчны бохирдол улам бүр өсөх болсон байна. Хятадад эрчим хүчний үр ашигтай хэрэглээний тогтолцоо ихээхэн сул, эрчим хүч хадгалах технологи олон улсын стандартаас ихээхэн хоцрогдсон байдал зэрэг нь сөргөөр нөлөөлжээ.

Аж үйлдвэрийн томоохон салбаруудыг цахилгаан, дулаанаар хангадаг цахилгаан станцуудын дийлэнх нүүрсээр ажилладаг технологитой тул Хятад улс нь хүлэмжийн хийн ялгаруулалтаараа дэлхийд тэргүүлэх болж олон улсын зүгээс томоохон эсэргүүцэлтэй

тулгараад байгаа юм.

Эдгээр асуудлыг цогцоор нь оновчтой шийдвэрлэхийн тулд Эрчим хүч хадгалах тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хууль зэргийг батлан засаг захиргааны хэрэгжүүлэгч байгууллагууддаа хайгуул судалгааны ажил, хадгалах, тээвэрлэхдээ “ecology acceptance” болон “ecology priority” хэмээх зарчмыг баримтлахын зэрэгцээ “Green GDP strategy” хэрэгжүүлэх, үйлдвэрийг олон улсын техникийн хамтын ажиллагаанд оролцоход дэмжих зэргээр бодлогоор зохицуулахад анхаарч байна.¹⁰


Экологийн тэнцвэрт байдлыг хангахын тулд эрчим хүчний бодлогодоо цэвэр эрчим хүчний эх үүсвэрийг эзэмших, эрчим хүч хадгалах, бохирдлыг хянах шинэ өндөр технологийг нэвтрүүлэхэд ихээхэн анхаарч байна. Байгаль орчноо хамгаалах үүднээс ГХО-дад тавих шаардлагыг өндөржүүлэх, байгаль орчныг хамгаалахад олон улсын санхүү, техникийн туслалцаа авахыг зорьж байна.

БНХАУ-ын эрчим хүчний дипломат бодлогын хэрэгжилт :

БНХАУ-ын тэргүүн Ху Жинтао “Одооноос эхлэн газрын тос нийлүүлэлтийн сувгийг нэмэгдүүлэх нь манай дэглэмийн хойшлуулшгүй чухал зорилтын нэг боллоо” хэмээн нэгэнтээ мэдэгдсэн нь Хятад улс газрын тосны эрэлд гарсныг гэрчилнэ. Хятадад эдүгээ газрын тосны стратегийн нөөц, импортын зах зээлийн эрэлт хэрэгцээ ихээхэн өссөн тул стратегийн нөөцийг ойрын жилүүдэд бий болгох зорилт тавин ажиллаж байна. Хятадын нутаг дэвсгэрт хийгдэж буй газрын тосны нөөц, орд газрын хайгуулын үр дүн сайнгүй байгаа тул Бээжин импортод анхаарлаа илүү хандуулж 2030 онд газрын тосны хэрэглээний 80 хувийг импортоор хангах зорилт тавьжээ. Эдүгээ Хятад улс гаднаас импортолж буй газрын тосны дийлэнх хувийг Ойрхи Дорнод, (Йемен, Оман, Саудын Араб, Иран) Африкын улс орнуудаас нийлүүлж байна.¹¹

Зураг 5

Figure 30: Oil Imports by Region of Origin (2006)



Source: EIA, China General Customs Administration, MITI, Korean Customs. Korean data is Jan-Nov 2006.

Газрын тосны импортын зах зээлээ төрөлжүүлж, тогтвортой, аюулгүй бүс нутаг, улс орноос газрын тос импортлох сонирхолтой байгаа юм.

Хятадын хувьд олборлолтоороо Саудын Арабын дараа хоёрдугаарт орж буй ОХУ-аас эрчим хүч дамжуулах хоолойгоор их хэмжээний тос, байгалийн хий авахыг эртнээс сонирхож байв. ОХУ-ын хувьд хүн ам цөөн, хөгжлөөр дорой Сибирь Алс Дорнодын бүс нутгийг хөгжүүлэх зорилгоор эрчим хүчний нөөцийг ашиглахад гадны хөрөнгө оруулалт ихээхэн шаардлагатай байгаа юм. Сүүлийн үед Сибирийн газрын тос, байгалийн хийн нөөц баялагтаа тулгуурлан Азийн эрчим хүчний зах зээлд өөрийн шинэ орон зайг бий болгож геополитикийн бодлогыг

¹⁰ Мөн тэнд х.7

¹¹ Daniel H. Rosen, Trevor Houser “China Energy: A Guide for the Perplexed” May, 2007. p.31

хэрэгжүүлэх сонирхол бүхий ОХУ, эдийн засгийн хурдацтай хөгжлөө дагаад өсөн нэмэгдэж буй эрчим хүчний эрэлт хэрэгцээгээ хангах түүхий эдийн эх үүсвэрийг идэвхтэй эрэлхийлж буй БНХАУ хоорондын хамтын ажиллагаа улам эрчимжиж байна. 2006 оны 3 дугаар сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр улс төр болон эдийн засгийн зорилтыг тусгасан олон тэрбум ам долларын гэрээ, хэлэлцээрүүдийг байгуулснаас газрын тос, байгалийн хийн чиглэлээр томоохон 3 баримт бичигт гарын үсэг зурсан байна. Үүнд: ОХУ-аас БНХАУ-д байгалийн хий нийлүүлэх тухай тунхаглал, ОХУ-ын болон БНХАУ-ын хооронд “Хамтарсан үйлдвэр байгуулах тухай хэлэлцээрт”-ээр ОХУ газрын тосны хайгуул, олборлолт, борлуулалтыг хариуцах, БНХАУ боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүнээ нийлүүлэх, худалдах чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилго бүхий хамтарсан үйлдвэр байгуулах, мөн “Зүүн Сибирь-Номхон Далай”-н дамжуулах хоолойн төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Төв Азийн орнуудтай эрчим хүчний хамтын ажиллагаагаа өргөжүүлж байна. Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд хайгуул, туршилт, судалгааны ажлууд тус бүс нутагт идэвхтэй явуулж үүний үр дүнд тус бүс нутгийн зарим улс орнуудтай эрчим хүчний хамтын ажиллагаагаа бэхжүүлжээ. Төв Ази дахь гол түнш болох Казакстанд хөрөнгө оруулж, улмаар газрын тос, байгалийн хийн дамжуулах хоолой тавихаар тохиролцсон, Туркменистан, Узбекистан зэрэг улсуудтай газрын тос, байгалийн хийн хамтарсан хайгуул хийхээр болсон нь томоохон амжилт юм. Эрчим хүчний өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээгээ хангахын тулд газрын тос, байгалийн хийн эх үүсвэрээ төрөлжүүлж, эрчим хүчний тээвэрлэлтийн аюулгүй байдалд анхаарах замаар аюулгүй байдлаа хангах зайлшгүй шаардлага гарч ирсэн тул Төв Азийн бүс нутагт хэрэгжүүлж буй эрчим хүчний стратеги бодлогын ач холбогдол цаашид ч улам бүр өсөн нэмэгдэх талтай. Тухайлбал 1997 онд Казахстаны Актюбинскийн газрын тосны орд газарт гурван тэрбум долларын хөрөнгө оруулахаар гэрээ байгуулж байсан бол өдгөө хөрөнгө оруулах чиглэлээр 12,5 тэрбум долларын гэрээ хийгээд байна¹². 1997 оны 7 дугаар сард Хятадын үндэсний газрын тос, байгалийн хийн корпораци Казахстаны газрын тос, хийн АКТОБЭОИЛ компанийн 60 хувийг худалдан авахаар болжээ.¹³

Хятадууд Африк тивийг мөн нэг хувилбар болгон сонгожээ. Зян Зэминь улс орны тэргүүн байхдаа 2002 оны хавар гадаад айлчлалынхаа төгсгөл болгож Нигери, Ливи, Тунис, Иранд айлчилсан нь газрын тосны салбарт Африк тив нь БНХАУ-ын чухал түнш байх ёстой гэдгийг илтгэн харуулсан хэрэг юм. Хятадын тэргүүн Африк тивд айлчлахаас өмнө тус улсын засгийн газар Африкын 31 орны нийт 1,3 тэрбум ам.долларын өрийг хүчингүй болгожээ. Хятад улс өөрсдийн “цэнхэр дуулгатуудаа” Конго, Либеру рүү илгээхээ анх удаа зөвшөөрч Африк тивд талтай буйгаа илэрхийлж байна.¹⁴

Томоохон хэрэглэгч болсон Энэтхэг улстай эрчим хүчний салбарт эрчимтэй хамтын ажиллагааг өргөжүүлж байгаа нь ихээхэн сонирхол татаж байгаа юм. Хэдийгээр эрчим хүчний салбарт томоохон өрсөлдөгчид ч гэсэн эдгээр улс Казакстанд газрын тосны хайгуулын ажилд хамтран ажиллах болсон төдийгүй Суданы газрын тос олборлох төсөлд хамтрах замаар бизнесийн түншүүд болсон улмаар Ираны газрын тосны зах зээлд ч хамтарч эхэлсэн байна. Цаашид нь Хятад, Энэтхэг хоёр улс эрсдлээ хуваах замаар олон улсын томоохон хэмжээний олборлох, тээвэрлэх төслүүдэд хамтран ажиллах сонирхолтой байгаа юм. 2005 оны 6 сард ОХУ, Хятад, Энэтхэгийн Гадаад харилцааны сайдууд ОХУ-ын Владивостокт албан бус уулзалт хийж ХАА, эрчим хүч, өндөр техник технологийн салбарт хамтын ажиллагаагаа хөгжүүлэх замаар эрчим хүчний стратегийн гурвалсан холбоо бүрдүүлэх тухай өгүүлсэн хамтарсан мэдэгдэл гаргажээ. Улмаар Энэтхэг улс Шанхайн Хамтын ажиллагааны байгууллагад элсэх хүсэлтээ гаргаад байгаа нь Төв Азийн бүс нутагт газрын тос, байгалийн хийн хамтын ажиллагааны төсөлд оролцох гарцыг эрж хайж байгаатай нь холбоотой.

¹² Yearbook on Chinese Communist Studies. 2001. Taiwan. P.6-108

¹³ fmpre.gov.cn.chn БНХАУ-ын ГХЯ-ий вэб хуудас

¹⁴ Зууны мэдээ сонин. 2004. 2. 2 № 26 (1536) “Хятадын нефтийн өсөн нэмэгдэж буй хэрэглээ буюу Африкийн зүг”

Ийнхүү БНХАУ байгалийн асар их нөөцөд өөрийн нөлөөгөө бэхжүүлэх сонирхлоо алхам алхмаар хэрэгжүүлж байна. Энэ утгаар Төв Азитай хил залгаа орших Хятадын Шинжаан Уйгурын район ч маш их ач холбогдол бүхий нутаг дэвсгэр нь, Таримын Булан (Tarim Basin) дахь судлагдаагүй газрын тос, байгалийн хий, төмөр, нүүрсний нөөц нь уян жигд хөгжиж буй Хятадын эдийн засагт ихээхэн хувь нэмэр оруулахын зэрэгцээ, газрын тосны нөөцийг тогтоон ашиглаж эхэлбэл тосны хувьд Ойрхи Дорнодоос хараат байдлыг бага ч болов сааруулах болно хэмээн үздэг. Барууны нөлөө харьцангуй бага Төв Азийн зах зээлд өөрийн байр сууриа олох, эдийн засаг, түүгээр дамжуулан улс төрийн нөлөөгөө бэхжүүлэх нь Хятадын нэгэн чухал ашиг сонирхол юм.

II. Монгол улс, БНХАУ-ын газрын тосны салбар дахь хамтын ажиллагаа:

Монгол улсын Зүүн ба Өмнөд хэсэг Тедяны бүсэд багтдаг учраас газрын тостой байх онолын магадлалтай гэж үздэг. БНХАУ-ын газрын тосны Үндэсний корпораци (CNPC)-ийн судалгаагаар Дорноговийн сав газарт байж болзошгүй нүүрс устөрөгчийн хэмжээ 100-150 сая тонн гэж дүгнэжээ. Английн British Petroleum компанийн судлаачид хамгийн их магадлалтай дэд сав газраар ашиглах нөөц нь 4.5 сая тонн, ордуудаар 2-3 сая тонн гэж үзжээ.

Сүүлийн үеийн (2000 оноос хойш) тооцоогоор Монголын газрын тосны таамаг нөөц 3-6 тэрбум баррель буюу ойролцоогоор 0.5-1.0 тэрбум тонн гэсэн тооцоо ч байдаг. Хятадын газрын тосны корпораци (CNPC)-ийн судалгааны хүрээлэнгийн хийсэн үнэлгээгээр Тамсагийн сав газрын газрын тосны геологийн нөөцийг 1.5 тэрбум баррель гэж тооцоолжээ. Тамсагийн сав газартай төстэй Хятадын орд газруудаас нийт нөөцийн ойролцоогоор 30 хувийг олборлох боломжтой байдаг байна. Өөрөөр хэлбэл, баталгаатай нөөц нь 0,5 тэрбум орчим баррель болох бөгөөд жилд дунджаар 400 орчим мянган тонн газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүн хэрэглэнэ гэж үзвэл энэхүү нөөц манай улсын 70-110 жилийн хэрэгцээг хангахад хүрэлцэхээр байгаа юм.¹⁵ Хэрэв Хятадын Үндэсний газрын тосны корпорацийн судалгааны хүрээлэнгээс гаргасан тооцоо бүрэн батлагдвал манай улс газрын тосны нөөцөөрөө дэлхийд 46 дугаар байранд орох магадлалтай юм.

Өнөөгийн байдлаар манай орны нутаг дэвсгэр дээр 5 компани 7 талбайд байгуулсан БХГ-ний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж үүнээс 2 компани газрын тос олборлож Хятад улсад экспортолж байна.

Өмнө дурьдсан БНХАУ-ын Хятадын Үндэсний газрын тосны корпораци (China National Petroleum Corporation буюу Petrochina) –ийн салбар "Дачин ойл фийлд лимитед" нь гадаад зах зээлд бие даасан үйл ажиллагаа явуулах эрх бүхий охин компани юм. Тус компанийн дүрмийн сан 5,74 тэрбум ам. доллар ба нийт 10,37 тэрбум ам. долларын хөрөнгөтэй, жилийн олборлолтын хэмжээ тогтмол 50 сая тонн байгаа юм. Тус компани газрын тос, байгалийн хийн олборлолтын үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ хайгуул судалгаа, газрын тосны бүтээгдэхүүний худалдаа эрхэлдэг бөгөөд үйл ажиллагааны гол чиглэл нь газрын тос, байгалийн хийн хайгуул, олборлолт юм.

Дачин ойл фийлд лимитед компани нь 2005 оны 8 дугаар сард Монгол улсын засгийн газартай байгуулсан Дорнод аймгийн Тамсагийн сав газрын XIX, XXI, XXII гэрээт талбайд газрын тосны хайгуул, олборлолт, тээвэрлэлт болон экспортын үйл ажиллагаа явуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх үүргийг Лондонгийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй "СОКО Интернейшнл ЛЛС"-ийн охин компани "СОКО Тамсаг Монгол" ХХК-ийг 93 сая ам. доллараар худалдан авч эрх үүргийг шилжүүлэн авчээ. Дачин ойл фийлд компани нь БНХАУ-ын 100%-н хөрөнгө оруулалттай Петрочайна дачин тамсаг /Монгол/ компанийг Монгол улсад байгуулан бүтээгдэхүүн хуваах зарчмаар Монгол улсын засгийн газрын баталсан гэрээний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.


БНХАУ-ын хөрөнгө оруулалттай нөгөө компани нь дээр дурьдсан "Sinopet"-ийн салбар

¹⁵ Ж.Цэвээнжав, "Нефть хийн аж үйлдвэрийн үндэс" УБ, 2005, х.37

компани ажээ. Австралийн Рок ойл компани Нескор энерги компанийн БХГ-ний эрхийг шилжүүлэн авч, Зүүнбаян, Цагаан элсний орд газраас туршилтын явцад олборлосон түүхий тосыг цуглуулах зорилгоор БНХАУ-ын Доншен жингон петролиум групп компанитай хамтран ажиллаж эхэлжээ. Доншен жингон петролиум групп БХГ-ний эрхийг 2002 онд шилжүүлэн авч Доншен газрын тос (Монгол) компанийг үүсгэн байгуулж, газрын тосны олборлолтыг сэргээж улмаар хайгуул, олборлолтын ажлаа эхлүүлжээ.

Доншен газрын тос (Монгол) компани 1994-2008 онуудад БХГ байгуулсан газрын тосны хайгуулын гэрээт талбайд 5,7 мянган км хоёр хэмжээст чичирхийллийн судалгаа хийж, хайгуулын болон үнэлгээний 70 цооног өрөмдөж, 111 сая ам долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. Тус компани 1998-2008 онуудад Зүүнбаян, Цагаан элсний орд газраас 960,2 мянган баррель газрын тос олборлож, 802,7 мянган баррель тос БНХАУ-д экспортолжээ. 2009 оны 3-р сарын байдлаар нэг цооногоос нийт 660,1 баррель тос олборложээ.

Зураг 6



Манай улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ жил ирэх тусам өсч байна. Тухайлбал 1998 оноос 2005 оныг хүртэл хэрэглээ жилийн 1,081 хурдацтай тогтвортой өсч байсан бол 2006-2008 он хүртэл илүү хурдтай өсөж жилийн нийт хэрэглээ өнөөдөр 884,1-д хүрсэн байна. Манай улсын 2008 оны газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг 1998 онтой харьцуулахад 10 жилийн хугацаанд 2 дахин өсчээ.


Өнөөг хүртэл газрын тосны хайгуулын үйл ажиллагаа 10 гаруй жил үргэлжилж байгаа боловч эдийн засгийн үр ашиг бүхий нөөц илрүүлж, үйлдвэрлэлийн олборлолт явуулах хэмжээнд хүрч чадахгүй байгаа нь газрын тосны үйл ажиллагаа нь бусад ашигт малтмалтай харьцуулахад ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт, цаг хугацаа шаарддаг, эрсдэл өндөртэй байдаг тус салбарын үйл ажиллагааны онцлогтой холбоотой. 1997-1999 онд дэлхийн зах зээл дээр нэг баррель түүхий тосны үнэ 23-аас 9 ам доллар хүртэл огцом унаснаар газрын тосны компаниуд хайгуулын үйл ажиллагаанд оруулах хөрөнгө оруулалтаа багасгасантай холбоотойгоор 1993-1999 онд нийт 11 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулагдсанаас 7 гэрээ нь цуцлагджээ. Үүнээс гадна манай улсын газрын тос агуулж болох магадлал бүхий сав газрууд бараг судлагдаагүй, далайд гарцгүй тул өмнө хөрш орны зах зээлээс бүрэн хамааралтай, дэд бүтэц сул хөгжсөн, цаг уурын эрс тэс уур амьсгалын улмаас үйл ажиллагаа нь улирлын чанартай тул богино хугацаанд, өндөр зохион байгуулалттай, эрчимтэй явуулахыг шаарддаг гэх мэт бусад хүчин зүйлээс шалтгаалж байгаа юм.

Гэвч өнгөрсөн оноос түүхий тосны үнэ 1999 онтой харьцуулахад 6-7 дахин өссөнөөр газрын тосны компаниудын хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд хөрөнгө оруулах

сонирхол эрс нэмэгдэж байна. Нөгөөтэйгүүр манай өмнөд хөрш улс эдийн засгийн хурдац, аюулгүй байдлаа хангах зорилгоор эрчим хүчний шинэ бодлого явуулах болсон нь манай улсын газрын тосны салбарын хөгжилд ихээхэн нөлөө үзүүлэх болсон. Үүний нэг тод илрэл нь БНХАУ-ын үндэсний хэмжээний томоохон компаниудын салбар манай газрын тосны салбарт хөрөнгө оруулж БХГ-ний дагуу ажиллаж хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлж 2010 оноос олборлолтын ажлаа эхлүүлэх бэлтгэл ажилдаа орсноос харагдаж байна.

1994-2006 онд манай улсын газрын тосны үйл ажиллагаанд нийт 253.2 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэж, 1997 оноос эхлэн улсын төсөвт орлого оруулах болсон юм. Тухайлбал, 1997-2005 онд улсын төвлөрсөн төсөвт 7.3 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 92.5 сая төгрөгийн орлого оруулсан байна.

Зураг 7




Зураг-3. Улсын төсөвт оруулсан орлого

2006 онд газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагааны хүрээ эрс нэмэгдэж хөрөнгө оруулалт өнгөрсөн онтой харьцуулахад 2.5 дахин өсч, 110 гаруй сая ам.долларт хүрчээ. Зөвхөн 2006 оны хөрөнгө оруулалтын хэмжээ нь сүүлийн 10 жилд газрын тосны үйл ажиллагаанд оруулсан нийт хөрөнгө оруулалттай тэнцэж байгаа юм. Петро чайна дачин тамсаг (Монгол) ХХК нь 2006 онд газрын тосны үйл ажиллагаанд 80 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж 1320 км² талбайг хамарсан 3 хэмжээст, 420 тууш км-т 2 хэмжээст чичирхийллийн судалгааг хийж, хайгуулын 53 цооног өрөмдөж, тос илэрсэн цооногт тосны ундаргыг нэмэгдүүлэх туршилт, үйлчилгээ, үнэлгээний ажлыг хийж байна. Үүний дүнд одоогоор 26 цооногийг олборлолтод шилжүүлж, 13 цооногоос хоногт дундажаар 1000-1300 баррель түүхий тос олборлож байна.

Мөн Цагаан элс, Зүүнбаян гэрээт талбайн зарим хэсэгт БХГ-ний дагуу газрын тосны үйл ажиллагаа явуулж буй БНХАУ-ын Доншен петролеум ХХК 2006 онд нийт 23.9 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж хайгуулын 6, үнэлгээний 11 цооног өрөмдөж, хоногт дундажаар 400-500 баррель тос олборлож байна. Хайгуул үнэлгээний энэхүү үйл ажиллагаанд нийт 140 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийснээс хайгуулын ажилд 80 сая ам.доллар, үнэлгээний ажилд 60 сая ам.доллар зарцуулжээ. 2007-2010 онд нийт 400 орчим хайгуул, үнэлгээний цооногуудыг өрөмдөх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа юм.

Доншен петролеум ХХК-ийн хувьд Зүүнбаян, Цагаан элсийн орд газруудад үнэлгээний талбай ялгаж, өмнө нь өрөмдсөн хуучин цооногуудыг сэргээх, тос илэрсэн цооногуудын ундаргыг нэмэгдүүлэх туршилт үйлчилгээ, шингэн хагалгааны ажлыг явуулж олборлолтод шилжүүлж, олборлолт, хадгалалтын барилга байгууламжид өргөтгөлийн ажлыг хийж байгаа бөгөөд 2007-2010 онд газрын тосны үйл ажиллагаанд нийт 52 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөжээ. Эдгээр гэрээлэгч компаниудын тооцоолж буйгаар дээр дурьдсан хайгуул үнэлгээний ажлыг амжилттай гүйцэтгэсэн тохиолдолд 2010 он гэхэд жилийн олборлолт 2.3 сая баррель болох юм.

Зураг 8



Гэрээлэгч компаниуд нь тодорхой хэмжээгээр хөрөнгө оруулж, хайгуул, олборлолтын үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулж байгаа боловч одоогоор газрын тосны томоохон орд, нөөц илрэх төлөв тодорхойгүй хэвээр байна. Энэ нь газрын тосны хайгуул судалгааны ажлын талаарх мэдээлэл хомс, олон улсын хэмжээнд сурталчлах ажил дутмаг байгаатай холбоотой.

Манай улс газрын тосны бүтээгдэхүүний импортоос ОХУ-аас бүрэн хамааралтай бол тус салбарын хөрөнгө оруулалтад өмнөд хөрш БНХАУ-ын хоёр компани голлох үүрэгтэй оролцож байгаа дүр зураг харагдаж байна. Газрын тосны салбарт ихэвчлэн Хятадын компаниуд давамгайлах болсон нь хэд хэдэн шалтгаантай ажээ. Үүнд :

- Газар зүйн байршлын хувьд манай улстай хил залгаа оршдог БНХАУ-ын Хайлаар, Дачин, Эрээн, Ордос, Манжуур зэрэг нутгийн газрын тосны сав газруудын геологийн нөхцөл нь манайтай ижил төстэй, газрын тостой холбогдсон үйл ажиллагааны зардал харьцангуй хямд байдаг байна.

- Эдийн засгийн хурдацтай хөгжлөө дагаад жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний эрэлт хэрэгцээгээ хангах түүхий эдийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор БНХАУ-ын Засгийн газар хөрш зэргэлдээ орнуудад газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагааг идэвхтэй явуулж эрчим хүчний аюулгүй байдлаа хангах бодлого баримталж байна. Энэ бодлогын хүрээнд гадаад орнуудад газрын тосны үйл ажиллагаа явуулахаар гэрээ байгуулсан компаниудад бага хүүтэй зээл олгох болсон ба Хятадын мэргэжлийн бус жижиг компаниуд энэ боломжийг ашиглаж мөнгө босгох сонирхолтой байна.

- Дэлхийн газрын тосны салбарын туршлагаас үзэхэд хөрөнгө оруулагч ялангуяа барууны томоохон компаниуд баталгаат болон тойм нөөц нь тогтоогдсон орд газруудын тухайн ордод үйл ажиллагаа явуулж буй жижиг компаниудыг худалдан авах замаар оролцдог байна. Гэтэл манай улсын хувьд хайгуулын нийт талбайн 94.3 хувьд судалгаа бараг хийгдээгүй, нөөц нь тогтоогдоогүй байгаа юм.

- Газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулж буй аливаа гэрээлэгч компаниуд эрсдэл өндөртэй газрын тосны хайгуулын ажлыг аль болох бага өртөг зардлаар явуулахыг чухалчилдаг тул туслан гүйцэтгэгчээр хамгийн хямд, техник технологийн шаардлага хангасан, ажиллах хүчтэй Хятадын компаниудыг ажиллуулах сонирхолтой байна. Орчин үед Хятадын компаниуд орд газрын нөөц ашиглах техник технологи аргачлалаараа дэлхийд тэргүүлэх болжээ. Жишээ нь: дэлхийн газрын тосны салбарт орд газрын нөөц ашиглалт дунджаар 30 хувьтай байхад Хятадад 50 хувьд хүрдэг. Хятадын энэ технологийг манай улсын гарц багатай, эдийн засгийн хувьд үр ашиг сайнгүй, жижиг орнуудад ашиглахаас өөр аргагүй байдаг юм.

Өнөөгийн байдлаар Петро чайна дачин тамсаг ХХК-д 88, Доншен петролеум ХХК-д 83 нийт 163 монгол хүн ажиллаж байгаа бөгөөд цаашид Тамсагийн сав газарт газрын тосны үйл ажиллагааны цар хүрээ өргөжихийн хэрээр манай улсын төсөвт оруулах орлогын хэмжээ нэмэгдэх, үндэсний нарийн мэргэшсэн боловсон хүчин бэлтгэгдэх, техник технологи хөгжих, улмаар манай улсын алслагдсан зүүн бүс нутгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд томоохон түлхэц

болох юм.

Стратегийн чухал ач холбогдолтой газрын тосны салбарт үндэсний компаниудын оролцоог дэмжиж байр суурийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Орос, Хятад хэмээх хоёр хөрш орны оролцоог тэнцвэртэй байлгах нь чухал бөгөөд өнөөгийн байдлаар хангамжийн талдаа ч, хөрөнгө оруулалтын хувьд ч, оролцооны хувьд тэгш бус байгааг анхаарч байх нь чухал байна. Энэ нь эдийн засгийн аюулгүй байдал, цаашлаад улс орны үндэсний эрх ашигтай холбогдох эмзэг асуудал билээ.

Монгол улс дэлхийн газрын тосны томоохон үйлдвэрлэгч ОХУ, асар том хэрэглэгч болох БНХАУ-ын хооронд оршин тогтнож буйн хувьд газрын тосны бүтээгдэхүүнийг 100 хувь гаднаас импортолдог, гадаадаас нэн хараат байдалтай байгааг харгалзан үзэж газрын тосны стратеги хөтөлбөрөө боловсруулсан. Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах сонирхол бүхий дотоодын компаниудыг ажлын байр харьцангуй олноор бий болох, мэргэжлийн өндөр ур чадвартай үндэсний боловсон хүчин бэлтгэх, тус салбарын техник, технологи, оюуны хөгжилд томоохон дэвшил гаргахад туслах замаар төрөөс бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Газрын тосны бүтээгдэхүүний импортын хамааралтай байдлыг бууруулахын тулд манай улсын холбогдох байгууллагууд дараах чиглэлд илүү түлхүү анхаарал хандуулж, үйл ажиллагаагаа чиглүүлээд байна. Үүнд:

Нэгдүгээрт, газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах нь манай орны эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулахаас гадна манай орны газрын тосны гаралтай бүтээгдэхүүнийг импортлох хэрэгцээ багасна.

Хоёрдугаарт, газрын тосны тандалт, судалгааны ажлыг эрчимжүүлж, шинэ эх үүсвэрийг олох, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн судалгаа хийх;

Гуравдугаарт, газрын тосны салбарт орох хөрөнгө оруулалтыг төр засгийн бодлогоор дэмжих, хууль эрх зүйн орчноо тогтвортой байлгаж, хөрөнгө оруулагчдыг дэмжиж ажиллах;

Дөрөвдүгээрт, газрын тосны салбарт олон талт оролцоог дэмжих, тэнцвэрт харьцааг барих;

Тавдугаарт, Монгол улсын хэрэгцээт шатахууныг шатахуун экспортлогч хэд хэдэн эх үүсвэртэй болгох талаар ОХУ, БНХАУ, Казахстан болон бусад улсуудтай засгийн газрын түвшинд тохиролцох явдал юм.

Казахстан, Кувейт зэрэг улсаас түүхий тос импортлох тохиролцоонд хүрсний зэрэгцээ Япон, БНСУ-ын хөрөнгө оруулагчид боловсруулах үйлдвэр байгуулахаар тохиролцож үйл ажиллагаагаа эхлүүлээд байгаа юм. Газрын тосны баялаг бүс нутаг Төв Азийн Казакстан болон Арабын орнуудтай /Кувейт/ хамтын ажиллагаагаа өргөжүүлж өмнө хүлээсэн стратегийн алдагдлаа нөхөхийг оролдож байна. Монголын “Мон ойл энд газ” (МОГ) Казакстанаас жилдээ 150 мянган тонн боловсруулсан бүтээгдэхүүн, 1.2-2.0 сая тонн түүхий тос импортлохоор¹⁶ тохирсны зэрэгцээ Кувейттэй жил бүр 1 сая тонн газрын тос худалдан авах хэлэлцээрийг 2008 онд байгуулсан.¹⁷

Дүгнэлт

Газрын тосны асуудал эдийн засгийн хүрээнээс хальж, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах байгууллагууд болон улс гүрнүүдийн хоорондын улс төрийн харилцааны салшгүй бүрэлдэхүүн болжээ. Эдийн засгийн глобалчлал эрчимжсэн өнөө үед эрчим хүчний нөөц баялгийг эзэмшигч болон хэрэглэгч улс хоорондын харилцан хамаарал улам ихэсч, хамтран ажиллах, өрсөлдөн тэмцэлдэх замаар зөрчилдөөнийг ил далд хэлбэрээр улам бүр хурцдахад хүргэж байна.

Дэлхийн газрын тосны зах зээлд хүчтэй нөлөө үзүүлэгч томоохон үйлдвэрлэгч ОХУ, томоохон хэрэглэгч БНХАУ-ын хооронд орших манай улс дэлхийн газрын тосны зах зээлийн төлөв байдлыг сайтар ажиглаж, импортын аюулгүй байдлаа хангах аюулгүй нөхцөл

¹⁶ www.open-government.mn

¹⁷ Үнэн сонин., 2008.10.16

бүрдүүлэхийн тулд олон талт, уян хатан дипломат ажиллагаа явуулах шаардлага улам бүр чухлаар тавигдаж байна. Газрын тосны бүтээгдэхүүнийг 100 хувь гаднаас импортолдог орны хувьд газрын тосны дэлхийн зах зээлийн үнийн хэлбэлзэл эдийн засагт шууд нөлөөлж, нийгэм-эдийн засгийн эмзэг байдлыг улам бүр даамжруулж эдийн засгийн аюулгүй байдалд ноцтой хохирол учруулах талтай.

Монгол улс газрын тосны салбарыг хөгжүүлэхэд дотоодын зах зээл хязгаарлагдмал, далайд гарцгүй, дэд бүтэц сайн бүрэлдээгүй, сүүлийн 30 орчим жил газрын тосны хайгуулын ажлыг орхигдуулсны улмаас судалгааны материал дутмаг, үйлчилгээний салбар дөнгөж хөгжиж эхэлж байгаа зэрэг бэрхшээл тулгарч байгаа боловч нөгөөтэйгүүр Монгол орон нь геологийн бүтцийн хувьд хөрш зэргэлдээх БНХАУ-ын сав газруудтай адил бүтэцтэй тул газрын тос олдох магадлал өндөр, түүхий тосны хэрэгцээ улам бүр нэмэгдэж буй Хятадын асар том зах зээл хөрш зэргэлдээ нээлттэй байгаа нь энэ салбарыг хөгжүүлэх асуудалд онцгой анхаарахыг шаардаж байгаа юм.

Газрын тосны аж үйлдвэр нь асар их хэмжээний зардал шаарддаг, өндөр эрсдэлтэй, манайд энэ салбарын үндэсний мэргэжилтэн дутмаг, газрын тосны орчин үеийн хайгуул, олборлолт, ашиглалт, борлуулалт, тээвэрлэлтийн туршлага зэргийг харгалзан Монгол улс ойрын ирээдүйд энэ салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, боловсруулах үйлдвэр байгуулахад анхаарч тодорхой үр дүнд хүрсэн билээ. Ингэхдээ бид хөрш хоёр орны зүгээс ирэх шууд болон дам нөлөөг сайтар бодолцож, тэдний оролцоог уг салбарт илүүтэй татахад ихээхэн анхаарч идэвх санаачлагатай ажиллах хэрэгтэй байна.

Хөрш хоёр орны газрын тосны зах зээл өөр өөрийн онцлогтой тул хэрэгжүүлж буй бодлого нь хязгаар бүс нутгийнхаа хөгжлийн асуудлыг тусган улмаар шинэ зах зээлийг эрэлхийлэн газрын тос, байгалийн хий дамжуулах замаар бүс нутгийнхаа нийгэм, эдийн засгийн байдлыг хөгжүүлэх ашиг сонирхлоороо нэгддэг тул манай улсын хувьд тун ашигтай таатай орчин хэмээн үзэх боломжтой. ОХУ-ын хувьд газрын тосны бодлогодоо үндэснийхээ ашиг сонирхлыг илүү ихээр тусгаж, Европ тивийн эрчим хүчний бодлогыг хянах болсон төдийгүй улмаар энэ нь Ази рүү чиглэгдэж байна. Өөрөөр хэлбэл, ОХУ нь Европоос Ази руу чиглэсэн эрчим хүчний бодлого хэрэгжүүлж Азийн эрчим хүчний зах зээлд нөлөө бүхий оролцогч болох сонирхолтой байна. БНХАУ нь “дарьтай торх” мэт тогтворгүй Ойрхи Дорнодын бүс нутгаас газрын тосны дийлэнх хэсгийг импортолж буй тул нэг бүс нутгаас хамааралтай байхгүйн тулд өөр байнгын тогтвортой эх үүсвэртэй болохыг Хятад зорьж байна.

2010 оноос эхлэн Хятадын компанийн хоёр томоохон ордын хайгуулын лицензийн хугацаа дуусч олборлолтыг эхлүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага гарч ирж байгаа юм. Гэхдээ өнөөг хүртэл Хятадын компаниудын хэтийн төлөвлөгөө, ордод түшиглэсэн боловсруулах үйлдвэрийг хэрхэн байгуулах талаарх байр суурь бүрэн тодорхойгүй ажээ. Олборлолт хийж эхэлснээр зарим судалгаанд өгүүлснээр жилд олборлох газрын тосны хэмжээ 2.3 сая баррель болох тул үүнийг дотооддоо боловсруулж өөрийн хэрэгцээнд эхний ээлжинд нийлүүлэх асуудлыг Хятадын компаниудтай тохиролцож чадвал манай улсын хувьд ОХУ-аас шууд хамааралтай байдал буурах өөрийн нөөц, баялгаараа хэрэглээгээ хангах тааламжтай нөхцөл бүрдэх юм.

Дан ганц нийлүүлэгч улсаас хамааралтай байгаа тул бидний зүгээс шинэ түншээ эрж хайх ажлыг эрчимжүүлэх, цэвэр буюу сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг эзэмших, түүхий тосоо дотооддоо боловсруулах технологи оруулж ирэх чиглэлд анхаарах шаардлагатай байна. Хятад улсын хувьд үр ашигтай хэрэглээнд суурилагдсан цэвэр эрчим хүчний хэрэглээг урт удаан хугацаанд бүрдүүлэхэд анхаарч энэ чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг гадаадын эрдэмтэдтэй хамтарч явуулах замаар туршлага хуримтлуулж, ур чадвараа дээшлүүлэхэд ихээхэн анхаарч байна. Ялангуяа сэргээгдэх эрчим хүч, нүүрсийг боловсруулж эрчим хүч үйлдвэрлэх технологиор дэлхийд ихээхэн үнэлэгдэх хэмжээнд хүрсэн тул өөрийн орны эрдэмтэн судлаачдын хамтарсан судалгааны ажлыг санаачлан эхлүүлэх шаардлагатай. Манай улс нүүрсний асар их баялаг нөөцтэй бөгөөд Хятад улс ч Шивээ овоо, Таван толгойн орд

газруудыг ихээхэн сонирхож байгаа тул хамтарч ажиллаж нүүрснээс газрын тос нэрж гаргах хамгийн сүүлийн үеийн байгаль орчинд халгүй технологийг нэвтрүүлэх замаар эрчим хүчний эх үүсвэрийг бүрдүүлбэл импортын хараат байдлаас гарах бас нэгэн гарц болох боломжтой. Шивээ овооны нүүрсний уурхайд түшиглэсэн томоохон цахилгаан станцыг Хятадтай хамтран байгуулахаар тохиролцоонд хүрээд байгаа нь уг асуудлыг бас нэг алхам урагшлуулсан хэрэг болов.

Дэлхийн газрын тосны салбарт эзлэх ОХУ-ын байр суурь буурч улмаар Хятад улсын байр суурь улам бүр өсөн нэмэгдэх хандлага ч ажиглагдаж байна. Өнөөгийн санхүүгийн хямралын үед Хятад улс томоохон санхүүжүүлэгчээр оролцож буй дэлхийн бараг бүх улс оронтой худалдаа, эдийн засгийн харилцаатай байгаа зэрэг нь дэлхий эдийн засгийн өсөлт Хятадын эрэлт хэрэгцээнээс ихээхэн шалтгаалах болсныг харуулна. Хятад улсын эрчим хүчний эрэлт хэрэгцээ дэлхийн эрчим хүчний ирээдүйн төлвийг тодорхойлох төлөвтэй байгаа тул түүний газрын тос экспортлогч орнуудтай харилцах харилцааг анхааралтай ажиглаж, олон улсын эрчим хүчний хамтын ажиллагааны томоохон төсөлд геополитикийн хүчин зүйлдээ тулгуурлан оновчтой хувилбарыг боловсруулж цагийг нь олж санал болгох боломжийг эрж хайх нь чухал юм. Тиймээс бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцохын тулд ОХУ, БНХАУ-ын хооронд тавигдах газрын тос, байгалийн хий дамжуулах хоолойн төсөлд оролцох хүсэл сонирхлоо орхилгүй боломжийг эрж хайсан хэвээр байх төдийгүй Төв Азийн бүс нутгаас ЗӨА-ийн бүс нутаг хүртэл тавигдах газрын тос, байгалийн хийн дамжуулах хоолойн төслүүдийг харьцуулан судлах нь чухал юм. Ирээдүйд олон улсын харилцааны нөхцөл байдал өөрчлөгдөж манайд ашигтай нөхцөл байдал үүсч болох тул тэр үед бэлэн байх үүднээс нутаг дэвсгэрээрээ босоо болон хэвтээ чиглэлээр дамнуулан тавьж болох газрын тос, байгалийн хийн дамжуулах хоолойн хувилбарыг судлан тогтоож, эдийн засгийн тооцоо судалгааг хийх ажлыг нэн түлхүү эхлүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, Каспийн тэнгисийн сав газрын тосыг ЗХА-ийн зах зээлд хямд өртгөөр дамжуулах хоолойн төсөлд тодорхой хэмжээний санхүүжилт хийх, олон улсын хамтын ажиллагааны хэлбэрээр оролцох замаар өөрийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах боломжийг судлаж тогтоох шаардлагатай байна. Ингэхдээ Хятадын томоохон газрын тосны компаниудад хөрөнгө оруулалтын таатай нөхцөл санал болгох замаар газрын тос, байгалийн хийн хоолойн төсөлд санхүүгийн дэмжлэг авах, дотоодын олборлох, боловсруулах үйлдвэр барихад хамтран ажиллах замаар хамтын ажиллагаагаа хөгжүүлж харилцан ашигтай хамтарч ажиллах өргөн боломж хоёр ард түмний дунд нээлттэй байна.

БНХАУ нь манай улсын газрын тосны бүтээгдэхүүний импортын хараат байдлыг бууруулахад нөлөөлж чадах хамгийн их магадлалтай улс бөгөөд хамгийн чухал нь хамтын эрх ашгийг харилцан хүндэтгэсэн, харилцан ашигтай, тогтвортой, итгэлтэй эрчим хүчний хамтын ажиллагааны үр ашигтай харилцааг хоёр орны хооронд бүрдүүлэхийн тулд илтгэлцлийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Өнөөгийн дэлхийн эдийн засгийн хөгжлийг тодорхойлох болсон Хятад улстай эдийн засгийн харилцаагаа улам бэхжүүлж, харилцан ойлголцож байр сууриа дэмжүүлэх замаар хамтран ажиллах зайлшгүй шаардлага бидний өмнө тулгарч байна.

Эцэст нь нэгэн жарныг үдэж, шинэ жарныг угтан авч буй манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа улам бүр хөгжиж олон өнгө төрхтэй, үр ашигтай шинэлэг үзэл санаагаар бэхжин батжихын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье!